



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 259

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалыг мөрдөж ажиллахыг тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, харьяа агентлаг болон байгууллагуудын удирдлагад даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын “Аргачлал батлах тухай” 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 116 дугаар тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын “Мэдээ, тайлан гаргах жагсаалт батлах тухай” 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 76 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ

**Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа
байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийх журам**

УХА0382
5519487
1116126781

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар зам, тээврийн салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид яам гэх/ болон харьяа агентлаг, байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь зам, тээврийн салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

1.3. Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь зам, тээврийн салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, яамны болон харьяа агентлаг, байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх болон харьяа байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зохион байгуулалт

2.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн яамны Төсвийн шууд захирагчтай байгуулах үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний төслийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн яамны харьяа байгууллагуудын төсвийн шууд захирагчтай байгуулах Үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний төслийг тухайн байгууллагууд тус тус боловсруулна.

2.2. Яамны Төсвийн шууд захирагчийн нэгжийн менежерүүдтэй байгуулах Үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний төслийг яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгуурлан холбогдох нэгжүүд боловсруулна.

2.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн яамны Төсвийн шууд захирагчтай, Төсвийн шууд захирагчийн яамны менежерүүдтэй байгуулах үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний төслийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж хянах ба үр дүнгийн гэрээг баталгаажуулах ажлыг Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгж зохион байгуулна.

2.4. Зам, тээврийн салбарын төрийн өмчит үйлдвэрийн газруудтай байгуулах ажил гүйцэтгэх гэрээг тухайн байгууллага боловсруулж, холбогдох салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах нэгж, Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж хянасны дараа Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгж баталгаажуулах ажлыг зохион байгуулна.

2.5. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захиралтай байгуулах Хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээг холбогдох салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах нэгж нь хянан Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгж баталгаажуулах ажлыг зохион байгуулна.

2.6. Үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй боловч тухайн жилийн явцад зайлшгүй хийх шаардлагатай болсон томоохон ажлыг нэмэлт ажил, үйлчилгээнд тооцон үнэлэх бөгөөд түүнд салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлох, эсвэл хэрэгжилтийг зохицуулахад тодорхой үр дүнгээ өгөх арга хэмжээ хамрагдана. Тухайн арга хэмжээний онцлогоос нь хамаарч тусгай захиалгат, эсвэл тусгай захиалгатаас бусад ажил, үйлчилгээ болохыг Төсвийн Ерөнхийлөн захирагч, Төсвийн шууд захирагч нар тухай бүр тодорхойлно.

2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдах тушаал, шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгавар болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээ тус бүрд хэрэгжүүлэх хугацааг тодорхой зааж өгнө. Энэхүү хугацааг сар, улирлаар тогтоох ба улирлаас урт хугацаанд үргэлжлэн хийгдэх ажлыг үе шат бүрд хуваарилан улирал тус бүрээр төлөвлөсөн байна.

2.8. Яамны нэгжийн менежерүүд, харьяа байгууллагын удирдлагууд 3 дугаар хавсралтад дурдсан тогтмол гаргах тайлан, мэдээллийг заасан хугацааны дотор гаргаж, гарын үсэг зурж баталгаажуулан хавсралтад заасан нэгжид ирүүлнэ. Мөн яамны удирдлагыг цаг үеэ олсон шуурхай мэдээллээр хангах, хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаанд зохион байгуулах зорилгоор Хавсралт 3-т дурдаагүй салбарын хууль, бодлого, төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, мэдээллийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгжид тухай бүр нэгтгэн ирүүлнэ.

2.9. Тайлан, мэдээ нь тухайн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хүрсэн үр дүн, гүйцэтгэсэн ажлын чанарыг бүрэн, тодорхой илэрхийлсэн байх ба тайлангийн үнэн зөв, байдлыг нэгж, байгууллагын удирдлага хариуцна.

2.10. Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь яамны нэгжүүдийн үйл ажиллагааны явцад улирал бүрийн дараа сарын эхний 10 хоногт багтаан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг 4 дүгээр хавсралтын дагуу нэгтгэн гаргаж, тайланг Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж, дүгнүүлнэ.

2.11. Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь яамны харьяа байгууллагуудын үйл ажиллагааны явцад хагас жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараа сарын эхний 10 хоногт багтаан дүнг 5 дугаар хавсралтын дагуу нэгтгэн гаргаж, тайланг сайдад танилцуулж, дүгнүүлнэ. Зам, тээврийн салбарын төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг жилд нэг удаа, жилийн эцэст дүгнэнэ.

2.12. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захиралтай байгуулсан хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээг холбогдох салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах нэгж дүгнэнэ.

2.13. Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгж нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж түүнд улирал бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хагас,

бүтэн жилээр сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

2.14. Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах зардлыг байгууллагын төсөвт тусган батлуулсан байна.

2.15. Тухайн жилд хийх хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөг Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулан батлуулна. Энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан, тогтмол хугацаанд хийгддэг хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлаас бусад хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын удирдамжийг тухай бүр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулна.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

3.1. Яамны нэгжүүд, харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэхэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам”, “Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 90 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам” болон холбогдох бусад баримт бичиг, аргачлалуудыг ашиглана.

3.2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэхдээ журмын 1 дүгээр хавсралтыг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг журмын 2 дугаар хавсралтыг баримтлан арга хэмжээ нэг бүрийн гүйцэтгэлийг өссөн дүнгээр гаргаж, тухайн зорилтын хүрэх түвшинтэй харьцуулан хувиар илэрхийлж дүгнэнэ. Үе шатанд хуваарилах боломжгүй, тогтмол хийгддэг дотоод арга хэмжээг дүгнэхдээ тухайн тайлангийн улиралд хийгдэх ажлууд бүрэн хийгдсэн бол 100% гэж үнэлнэ.

3.3. Засгийн газрын гишүүнээс аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал болон бусад үүрэг даалгаврын хэрэгжилт, хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг баримтална.

3.4. Журмын 1, 2 дугаар хавсралтад заагаагүй хүрэх түвшинтэй арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалыг баримтална.

3.5. Үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төсвийн шууд захирагчийн үйл

ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", "Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг баримтална.

3.6. Аргачлалын дагуу үнэлсний дараа тухайн газрын үйл ажиллагааны чанарыг үнэлэх зорилгоор арга хэмжээ тус бүрд төлөвлөгөөт хугацаа болон ажлын чанараас хамаарч дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

3.6.1. Арга хэмжээний хэрэгжилт нь төлөвлөсөн хугацаанаас хэтэрсэн бол удааширсан гэж үзэж, 1 шат бууруулан үнэлнэ. Хэрэгжих хугацаа нь санхүүжилт болон хамтран хэрэгжүүлэгч салбарын бус байгууллагаас шалтгаалан хоцорсон арга хэмжээнд энэ заалт хамаарахгүй.

3.6.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь тухайн ажлыг холбогдох шалгуурын дагуу үнэлэхдээ ажлын чанараас хамааран 1 шатаар өсгөх буюу бууруулж үнэлж болно.

3.6.3. Бодлогын зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын явцад 12 сарын хугацаанд ахиц гараагүй бол удааширсан, 18 сарын хугацаанд ахиц гараагүй бол тасарсанд тооцно.

3.7. Бодлогын баримт бичгийн зорилт нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлт нь шаардлага хангаагүй, эсхүл шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, төсөв хөрөнгө тодорхойгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан зэргийг баримтаар нотолсон бол "үнэлэх боломжгүй" гэж дүгнэнэ.

3.8. Тайланг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлээгүй бол тухайн арга хэмжээг өмнөх улирлын дүнгээр, анхны удаа үнэлэгдэж байгаа бол "тасарсан" буюу "тэг хувь" гэж үнэлнэ.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим, хүлээгдэж буй үр дүн, түүний ашиглалт

4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дараах зарчмыг баримтална.
Үүнд:

4.1.1. Шударга, хараат бус байх;

4.1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт нь ил тод байх;

4.1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

4.1.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан дүгнэлт нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх

4.1.5. Хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;

4.1.6. Хяналт-шинжилгээ үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч болон олон нийтийн оролцоог хангасан байх;

4.1.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтан хариуцдаг байх.

4.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц, үр өгөөжийг дээшлүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад мөрдлөг болохуйц тодорхой санал, зөвлөмжийг тусгасан байна.

4.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн тайлангийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн тухайн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцан зохион байгуулна.

4.4. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын тайланг холбогдох журмын дагуу архивын нэгж болгон бүрдүүлж, дараа оны нэгдүгээр улиралд багтаан архивын эрхлэгчид хүлээлгэн өгнө.

Тав. Хариуцлага

5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллага, нэгжийн үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр хагас, бүтэн жилээр дараалан хангалтгүй үнэлгээ авсан байгууллага, нэгжийн даргыг Төрийн албаны тухай хуулийн 23.1-д заасны дагуу албан тушаал бууруулах саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжилна.

5.2. Дараах зөрчил гаргасан албан тушаалтанд Төрийн албаны тухай, Төсвийн тухай болон холбогдох бусад хууль, Байгууллагын дотоод журамд зааснаар хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:

5.2.1 Энэхүү журмын 2.8 дахь хэсэгт заасныг зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан;

5.2.2. Өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй;

5.2.3. Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, тайланг удирдлагад танилцуулаагүй.

----- оОо -----

**“Зам, тээврийн хөөжлийн яам болон харьяа байгууллагын үйл ажиллагааг
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын Хавсралт**

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Ажлын төрөл	Хүрэх түвшингийн тодорхойлолт	Тухайн ажлын хэрэгжилтийн түвшингийн үнэлгээнд хамаарах үе шат			
		0%	40%	70%	100%
Бодлогын болон эрх зүйн баримт бичиг боловсруулах	УИХ-аар батлуулах	Ажил хийгдээгүй, Ажлын хэсэг байгуулсан, ажлын даалгавар батлагдсан байх	Анхны төсөл боловсруулсан, Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжүүлсэн байх /Буцаагдсан бол 0%-д хамаарах/	Төслийг эцэслэн боловсруулсан /Яамдаас санал авсан, Үзэл баримтлал батлагдсан/, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлсэн байх /Буцаагдсан бол 40%-д хамаарах/	УИХ-аар хэлэлцл баталсан бай
	Засгийн газраар батлуулах	Ажил хийгдээгүй, Ажлын хэсэг байгуулсан, ажлын даалгавар батлагдсан байх	Төсөл боловсруулалтын шатанд	Төслийг эцэслэн боловсруулсан /Яамдаас санал авсан байх/, Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжүүлсэн байх /Буцаагдсан бол 40%-д хамаарах/	Засгийн газрын хуралдаанаар баталсан бай /Буцаагдсан бол 40%-д хамаарах/
	Сайдын тушаалаар батлах	Ажил хийгдээгүй, Ажлын хэсэг байгуулсан, ажлын даалгавар батлагдсан байх	Төслийн боловсруулалтын шатанд, Холбогдох газраас санал авсан байх	Эцсийн төсөл боловсруулсан, Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжүүлсэн байх /Буцаагдсан бол 40%-д хамаарах/	Сайдын тушаалаар батлагдсан бай
Стандарт, норм, норматив батлуулж, мөрдүүлэх	Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоол гаргуулах	Ажил хийгдээгүй, Шинээр боловсруулж батлуулах стандарт, нормын судалгаа гарсан, сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөө батлагдсан байх	Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан, гэрээт байгууллагаас ирүүлсэн стандарт, норм, техникийн баримт бичгийн төсөлд редакци, шүүмж, дүгнэлт хийлгэсэн байх	Зам, тээврийн салбарын ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн байх /Буцаагдсан бол 40%-д хамаарах	Стандарт, хэмж зүйн газрын стандартчиллы техникийн хороодын хурла хэлэлцүүлж, дэмжигдэн тогтоо шийдвэр гаргаса байх
Эрдэм, шинжилгээ, шинэ технологийн судалгаа хийх	Судалгааны ажил гүйцэтгэх	Ажил хийгдээгүй, судалгааны ажлын даалгавар батлуулсан байх	Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан, гэрээт зөвлөхөөс ирүүлсэн судалгааны ажлын тайлан д дүгнэлт хийлгэсэн байх	Судалгааны ажлын дүн, тайлант Зам, тээврийн салбарын ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн байх	Судалгааны ажл захиалагч алба ёсоор хүлээн авс байх

Бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх	Бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх /ОУ-ын хэмжээнд зарлах төндөрл/	Зөвлөхийн үйлчилгээ авах /Техникийн/	Ажил хийгдээгүй, Шийдвэр гарсан байх	Ажлын болон техникийн даалгавар батлуулсан, Зураг төсөл боловсруулж батлуулсан байх	Хөрөнгө шийдэгдсэн байх, Гүйцэтгэчийг шалгаруулсан байх	Гэрээ байгуулж ажлаа эхлүүлсэн байх
	Бүтээн байгуулалтын ажлыг дуусгах	Ажил хийгдээгүй, Төндөр зарласан байх	Ажил хийгдээгүй, Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар батлуулсан байх	Төндөр шалгарсан, Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байх, Ажлын явц 60% хүртэл	Ажлын явц 60-89% хүртэл	Ажлын явц 90-100% хүртэл Ажлын дүнг баталгаажуулж хүлээн авсан байх
Бараа, ажил үйлчилгээ худалдан авалт	Тонот төхөөрөмж худалдан авах, ашиглалтад оруулах	Ажил хийгдээгүй, Төндөрийн баримт бичиг батлагдсан байх	Төндөр шалгаруулалт явагдаж буй	Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байх, Ажлын явц 60-100% хүртэл	Ажлын явц 60-100% хүртэл	Ажлын явц 90-100% хүртэл Улсын комисс хүлээлгэж өгсөн байх
	Зураг төсөл боловсруулах	Ажил хийгдээгүй, Ажлын даалгавар батлуулсан байх	Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байх, Ажлын явц 60% хүртэл	Уулзалт, хурал зөвлөгөөн зохион байгуулсан, Эцсийн хувилбарыг тохирсон байх	Хурал, зөвлөгөөн, айлчлалын бэлтгэлийг бүрэн хангасан байх	Хурал, зөвлөгөөн зохиогдон байгуулсан байх
Гаднаад харилцааг хөгжүүлэх	Гэрээ, хэлэлцээр байгуулах	Ажил хийгдээгүй, Хэлэлцээр, санаамж бичиг, протоколын Монгол Улсын талын төслийг боловсруулсан байх	Нөгөө талд хүргүүлж, санал авсан. Яамдаас санал авсан байх.	Хурал, зөвлөгөөн, айлчлалын бэлтгэлийг бүрэн хангасан байх	Хурал, зөвлөгөөн, айлчлалын бэлтгэлийг бүрэн хангасан байх	Хурал, зөвлөгөөн зохиогдон байгуулсан байх
	Хурал, зөвлөгөөн, айлчлал зохион байгуулах	Ажил хийгдээгүй, урилга хүргүүлсэн байх	Нөгөө талаас хариу ирсэн, харилцан санал солилцсон байх	Хурал, зөвлөгөөн, айлчлалын бэлтгэлийг бүрэн хангасан байх	Хурал, зөвлөгөөн, айлчлалын бэлтгэлийг бүрэн хангасан байх	Хурал, зөвлөгөөн зохиогдон байгуулсан байх
Ханалт шалгалт хийх	Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн ханалт шалгалт хийх	Ажил хийгдээгүй, Шалгалтын удирдамж батлагдсан байх	Шалгалт хийж байгаа	Шалгалт хийсэн, тайлан гарсан байх	Шалгалт хийсэн, тайлан гарсан байх	Тайланг удирдлага танилцуулсан шалгалтын дүнг хүргүүлсэн байх

	Дотоод аудит хийх	Ажил хийгдээгүй. Аудитын төлөвлөгөө, удирдамж батлагдсан байх	Аудит хийх маягт, асуулга боловсруулсан, Эрсдлийн үнэлгээ хийсэн байх	Аудитын хийсэн, Аудитын тайлан гарсан байх	Тайланг удирдл танилцуулсан Дотоод аудитаа хорооны тогто гарсан, зөвлөмж хүргүүлсэн
	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Ажил хийгдээгүй, Шалгалтын удирдамж батлагдсан байх	Тайлан, мэдээ цуглуулсан байх	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байгаа	Хяналт-шинжилг үнэлгээний тайл удирдлагад танилцуулсан, д хүргүүлсэн бай

----- 000 -----

“Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын үйл ажиллагаа
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын Хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Ажлын төрөл	Хүрэх түвшингийн тодорхойлолт	Тухайн ажлын хэрэгжилтийн түвшингийн үнэлгээнд хамаарах үе шат			
		0%	30%	70%	100%
Бодлогын болон эрх зүйн баримт бичиг боловсруулах	УИХ-аар батлуулах	Ажил хийгдээгүй, Ажлын хэсэг байгуулсан, ажлын даалгавар батлагдсан байх	Анхны төсөл боловсруулсан, Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжүүлсэн байх /Буцаагдсан бол 0%-д хамаарах/	Төслийг эцэслэн боловсруулсан /Яамдаас санал авсан, үзэл баримтлал батлагдсан/, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлсэн байх /Буцаагдсан бол 40%-д хамаарах/	УИХ-аар хэлэлц баталсан байх
	Засгийн газраар батлуулах	Ажил хийгдээгүй, Ажлын хэсэг байгуулсан, ажлын даалгавар батлагдсан байх	Төсөл боловсруулалтын шатанд	Төслийг эцэслэн боловсруулсан /Яамдаас санал авсан байх/, Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжүүлсэн байх /Буцаагдсан бол 40%-д хамаарах/	Засгийн газрын хуралдаанаар баталсан байх /Буцаагдсан бол 40%-д хамаарах/
	Сайдын тушаалаар батлах	Ажил хийгдээгүй, Ажлын хэсэг байгуулсан, ажлын даалгавар батлагдсан байх	Төслийн боловсруулалтын шатанд, Холбогдох газраас санал авсан байх	Эцсийн төсөл боловсруулсан, Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжүүлсэн байх /Буцаагдсан бол 40%-д хамаарах/	Сайдын тушаалаар батлагдсан байх
Стандарт, норм, норматив батлуулж, мөрдүүлэх	Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоол гарлуулах	Ажил хийгдээгүй, Шинээр боловсруулж батлуулах стандарт, нормын судалгаа гарсан, сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөө батлагдсан байх	Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан, гэрээт байгууллагаас ирүүлсэн стандарт, норм, техникийн баримт бичгийн төсөлд редакци, шүүмж, дүгнэлт хийлгэсэн байх	Зам, тээврийн салбарын ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн байх /Буцаагдсан бол 40%-д хамаарах	Стандарт, хэмжээ зүйн газрын стандартчиллы техникийн хороодын хурлаар хэлэлцүүлж, дэмжигдэн тогтоол, шийдвэр гарсан байх
Эрдэм, шинжилгээ, шинэ технологийн судалгаа хийх	Судалгааны ажил гүйцэтгэх	Ажил хийгдээгүй, судалгааны ажлын даалгавар батлуулсан байх	Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан, гэрээт зөвлөхөөс ирүүлсэн судалгааны ажлын тайлан д дүгнэлт хийлгэсэн байх	Судалгааны ажлын дүн, тайланг Зам, тээврийн салбарын ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн байх	Судалгааны ажлыг захиалагч албан ёсоор хүлээн авсан байх

“Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын үйл ажиллагаа
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын Хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Хяналтанд байх арга хэмжээ	20 ... онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Үүнээс:		Дундаж хувь	Биелэлт /Хувиар/						
			Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Тухайн улиралд тасарсан арга хэмжээ /Өссөн дүнгээр/		100	90	70	50	40	30	
1	Үр дүнгийн гэрээ болон ажил гүйцэтгэх гэрээний биелэлт											
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт											
3	Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт											
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт											
5	Сайдын тушаалын биелэлт											
6	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлт											
7	Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт											
8	Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ											
9	Ил тод нээлттэй байдлын үнэлгээ											
10	Нэмэлт ажил, үйлчилгээ											
	Нийт дүн											

----- ооо -----

“Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын үйл ажиллагаа
нэгжүүдийн үйл ажиллагааны явцад хийсэн
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Хяналтанд байх арга хэмжээ	20 ... онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Үүнээс:		Дундаж хувь	Биелэлт /Хувиар/						
			Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Тухайн улиралд тасарсан арга хэмжээ /Өссөн дүнгээр/								
1	Үр дүнгийн гэрээний биелэлт											
2	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын биелэлт											
3	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт											
4	Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт											
5	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт											
6	Сайдын тушаалын биелэлт											
7	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлт											
8	ЗГ-ын хуралдаанд оруулах асуудлын төлөвлөгөөний биелэлт											
	Сайдын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөний биелэлт											
9	Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт											
10	Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт											
11	Ил тод нээлттэй байдлын үнэлгээ											
12	Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ											
13	Нэмэлт ажил, үйлчилгээ											
	Нийт дүн											

----- 000 -----

Бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх	Бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх /ОУ-ын хэмжээнд зарлах мөндөрт/	Ажил хийгдээгүй, Шийдвэр гарсан байх	Ажлын болон техникийн даалгавар батлуулсан, Зураг төсөл боловсруулж батлуулсан байх	Хөрөнгө шийдэгдсэн байх, Гүйцэтгэгчийг шалгаруулсан байх	Гэрээ байгуул ажааа эхлүүлсн байх
	Зөвлөхийн үйлчилгээ авах /Техникийн/	Ажил хийгдээгүй, Төндөр зарласан байх	Төндөр шалгарсан, Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байх. Ажлын явц 60% хүртэл	Ажлын явц 60-89% хүртэл	Ажлын явц 90-100% хүртэл Ажлын дүнг баталгаажуулж хүлээн авсан байх
	Бүтээн байгуулалтын ажлыг дуусгах	Ажил хийгдээгүй, Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар батлуулсан байх	Зураг төсөл боловсруулсан, Гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулж ажил эхэлсэн байх, Ажлын явц 60% хүртэл	Ажлын явц 60-89% хүртэл	Ажлын явц 90-100% хүртэл Улсын комисс хүлээлгэж өгсөн байх
Бараа, ажил үйлчилгээ худалдан авалт /бүтээн байгуулалтаас бусад арга хэмжээ/	Тоног төхөөрөмж худалдан авах, ашиглалтад оруулах	Ажил хийгдээгүй, Төндөрийн баримт бичиг батлагдсан байх	Төндөр шалгаруулалт явагдаж буй	Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байх	Актаар хүлээн авсан байх
	Зураг төсөл боловсруулах	Ажил хийгдээгүй, Ажлын даалгавар батлуулсан байх	Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байх, Ажлын явц 60% хүртэл	Ажлын явц 60-100% хүртэл	Захиалагч хүлээ авсан байх
	Гэрээ, хэлэлцээр байгуулах	Ажил хийгдээгүй, Хэлэлцээр, санамж бичиг, протоколын Монгол Улсын талын төслийг боловсруулсан байх	Нөгөө талд хүргүүлж, санал авсан. Яамдаас санал авсан байх.	Уулзалт, хурал зөвлөгөөн зохион байгуулсан, Эцсийн хувилбарыг тохирсон байх	Хэлэлцээр, санамж бичиг, протокол байгуул албажуулсан байх
Хяналт шалгалт хийх	Хурал, зөвлөгөөн, айлчлал зохион байгуулах	Ажил хийгдээгүй, урилга хүргүүлсэн байх	Нөгөө талаас хариу ирсэн, харилцан санал солилцсон байх	Хурал, зөвлөгөөн, айлчлалын бэлтгэлийг бүрэн хангасан байх	Хурал, зөвлөгөөн айлчлал зохион байгуулсан байх
	Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх	Ажил хийгдээгүй, Шалгалтын удирдамж батлагдсан байх	Шалгалт хийж байгаа	Шалгалт хийсэн, тайлан гарсан байх	Тайланг удирдлагад танилцуулсан шалгалтын дүнч хүргүүлсэн байх

	Дотоод аудит хийх	Ажил хийгдээгүй. Аудитын төлөвлөгөө, Удирдамж батлагдсан байх	Аудит хийх маягт, асуулга боловсруулсан, Эрсдлийн үнэлгээ хийсэн байх	Аудитын хийсэн, Аудитын тайлан гарсан байх	Тайланг удирдлагад танилцуулсан Дотоод аудитыг хорооны тогтоо гарсан, зөвлөмжийг хүргүүлсэн
	Хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх	Ажил хийгдээгүй, Шалгалтын удирдамж батлагдсан байх	Тайлан, мэдээ цуглуулсан байх	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байгаа	Хяналт- шинжилгээ, үнэлгээний тайланг удирдлагад танилцуулсан, дүнг хүргүүлсэн байх

----- ооо -----

“Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын үйл ажиллагаа
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын Хавсралт

**ЯАМНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮД, АГЕНТЛАГ,
ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ТОГТМОЛ ГАРГАХ ТАЙЛАН, МЭДЭЭЛЛИЙН
НЭР ТӨРӨЛ, ХУГАЦАА**

№	Тайлан, мэдээллийн нэр	Яамны бүтцийн нэгжүүдийн хооронд өгөх тайлан, мэдээлэл			Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад өгөх тайлан, мэдээлэл		
		Хугацаа	Хариуцан гаргах газар /хэлтэс/, байгууллага	Хүлээн авах газар	Хугацаа	Хариуцан нэгтгэж гаргах газар	Хүлээн авах газар байгууллага
0	1	2	3	4	5	6	7
Нэг. Долоо хоногт							
1.1.	Сайд болон Төрийн нарийн бичгийн даргын шуурхай зөвлөгөөн дээр яамны удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт	7 хоног бүрийн Лхагва гарагийн 15 цагаас өмнө	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ТЗУГ	7 хоног бүрийн Пүрэв гарагийн 14 цагаас өмнө	ТЗУГ	ХШҮДА
1.2.	Яамны вэб сайтын мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэх, ирсэн санал, хүсэлтэнд хариу өгөх, мэдээлэх	Тухай бүр	Яамны нэгжүүд,	ТЗУГ	-	-	-
1.3	Зам, тээврийн салбарт гарсан осол, зөрчлийн мэдээ, мэдээлэл	Тухай бүр	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ТЗУГ	Тухай бүр	ТЗУГ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
Хоёр. Сард							
2.1.	Сарын үйл ажиллагааны мэдээлэл	Дараа сарын 03-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	Дараа сарын 06-ны дотор	ТЗУГ	ЗГХЭГ
2.2.	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал /хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч нэмж тусган хэлэлцүүлэх шаардлагатай асуудал/	Сар бүрийн 25-ны дотор	Яамны нэгжүүд	БТГ	Сар бүрийн 30-ны дотор	БТГ	ЗГХЭГ
2.3	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж, Хөгжлийн банкны санхүүжилтээр	Сар бүрийн 30-ны дотор	Яамны нэгжүүд,	БТГ	Дараа сарын 03-ны дотор	БТГ	Сангийн яам

	хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний биелэлт		агентлаг, харьяа байгууллагууд		Дараа оны 03 сарын 01-ны дотор	ХШУДАГ	ЗГХЭ
2.4	Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт	Сар бүрийн 01-ний дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ	Дараа сарын 06-ны дотор	БТГ	Сангийн
2.5	Тухайн оны батлагдсан урсгал зардлын гүйцэтгэл	Сар бүрийн 01-ний дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ	Дараа сарын 06-ны дотор	БТГ	Сангийн
2.6	Иргэдээс байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын барагдуулалтын мэдээ	Сар бүрийн 25-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	Улирал бүрийн дараа сарын 10-ны дотор	ТЗУГ	ЗГХЭ
2.7	УИХ-ын гишүүдээс ирүүлсэн хариутай бичгүүдийн барагдуулалтын мэдээ	Сар бүрийн 25-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг	ТЗУГ	Улирал бүрийн дараа сарын 05-ны дотор	ТЗУГ	ЗГХЭ
2.8	Зам, тээврийн салбарын үйл ажиллагааны статистик мэдээ, мэдээлэл	Сар бүрийн 10-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ			
Гурав. Улиралд							
3.1.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн Төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	Дараа оны 04 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭ
3.2.	Яамны нэгжийн менежерийн Төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний жилийн биелэлт	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	Яамны нэгжүүд	ХШУДАГ	Улирал бүрийн дараа сарын 10-ны дотор	ХШУДАГ	
3.3.	Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	02 сарын 01, 07 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭ
3.4.	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	01 сарын 20, 06 сарын 25-ны дотор	ХШУДАГ	Сангийн я
3.5.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	Улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ТЗУГ	01 сарын 15, 07 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭ
3.6.	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	Яамны нэгжүүд	ХШУДАГ	Улирал бүрийн сүүлийн сарын 30-ны дотор	ХШУДАГ	

3.7	Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт	Улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ХШУДАГ	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	ХШУДАГ	
3.8	Төрийн нарийн бичгийн дарга тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт	Улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ХШУДАГ	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	ХШУДАГ	
3.9	Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт	Улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	ХШУДАГ	
3.10	Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт	Улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	ХШУДАГ	
3.11	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийн нэгдсэн тайлан	Улирал бүрийн дараа сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ХШУДАГ	Дараа оны 04 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭ
3.12	Худалдан авах ажиллагааны тайлан	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ	Улирал бүрийн дараа сарын 25-ны дотор	БТГ	Сангийн
Дөрөв. Хагас, бүтэн жилд							
4.1.	Төсвийн ерөнхийлөн захирагчтай Төсвийн шууд захирагчийн байгуулах үр дүнгийн гэрээний төсөл	12 дугаар сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд	ХШУДАГ	12 дугаар сарын 25-ны дотор	ХШУДАГ	ТЗУГ
4.2	Төсвийн шууд захирагчтай нэгжийн менежерүүдийн байгуулах үр дүнгийн гэрээний төсөл	12 дугаар сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд	ХШУДАГ	12 дугаар сарын 25-ны дотор	ХШУДАГ	ТЗУГ
4.3.	Яамны нэгжийн менежер тухайн нэгжийн төрийн жинхэнэ албан хаагчидтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэсэн тухай илтгэх хуудас	Хагас, бүтэн жилийн сүүлийн сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ, ХШУДАГ			
4.4.	Төсвийн ерөнхийлөн захирагчтай Агентлаг, харьяа байгууллагын Төсвийн шууд захирагчдын байгуулах үр дүнгийн гэрээ, харьяа байгууллагын захиралтай байгуулах гэрээний төсөл	12 дугаар сарын 15-ны дотор	агентлаг, харьяа байгууллагууд	ХШУДАГ, Яамны нэгжүүд	12 дугаар сарын 20-ны дотор	ХШУДАГ	ТЗУГ

4.5.	Төсвийн ерөнхийлөн захирагчтай Агентлаг, харьяа байгууллагын Төсвийн шууд захирагчдын байгуулсан үр дүнгийн гэрээ, харьяа байгууллагын захирагчтай байгуулсан гэрээний тайлан, илтгэх хуудас	Хагас, бүтэн жилийн сүүлийн сарын 20-ны дотор	агентлаг, харьяа байгууллагууд	ХШУДАГ	Хагас, бүтэн жилийн дараа сарын 10-ны дотор	ХШУДАГ	
4.6.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирагчтай байгуулах хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээний төсөл	12 дугаар сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	12 дугаар сарын 20-ны дотор	ТЗУГ	
4.7.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирагчтай байгуулсан хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээний тайлан	12 дугаар сарын 15-ны дотор	Төсөл хэрэгжүүлэх нэгж	Яамны нэгжүүд	12 дугаар сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд	
4.8.	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын биелэлт	08 сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ТЗУГ	09 дүгээр сарын 01-ны дотор	ХШУДАГ	Сангийн
4.9.	Үндэсний хөтөлбөрүүдийн биелэлт	07 сарын 15, 03 сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ	Дараа оны 04 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭГ
4.10.	Төрөөс баримтлах бодлогын биелэлт	07 сарын 15, 03 сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ	Дараа оны 04 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭГ
4.11.	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн биелэлт	Дараа оны 01 сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ	Дараа оны 02 сарын 01-ний дотор	ХШУДАГ	Үндэсний хөгжлийн
4.12.	Байгууллагын ил тод байдлын тайлан	Хагас, бүтэн жилийн сүүлийн сарын 25-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ТЗУГ	Дараа оны 04 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭГ, Д
4.13.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	03 сарын 01-ний дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ	Дараа оны 04 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭГ
4.14.	Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиглуулах талаар байгууллагын тухай жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	03 сарын 15-ны дотор	ТЗУГ	ХШУДАГ	Дараа оны 04 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭГ
4.15.	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл	03 сарын 01-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ	03 сарын 15-ны дотор	БТГ	Сангийн я

4.16.	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл	07 сарын 01-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ	06 сарын 25-ны дотор	БТГ	Сангийн
4.17	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл	3 сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ	04 сарын 1-ний дотор	БТГ	Сангийн
4.18.	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах санал	12 дугаар сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд	БТГ	01 сарын 10-ны дотор	БТГ	ЗГХЭ
4.19	Сайдын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөнд оруулах санал	12 дугаар сарын 25-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ			
4.20	Хөдөлмөр, нийгмийн 3 талт зөвшилцлийн гэрээний төсөлд оруулах санал	12 дугаар сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ТЗУГ	12 дугаар сарын 25-ны дотор	ТЗУГ	Салбарын ийн холбо НХХЯ
4.21	Хөдөлмөр, нийгмийн 3 талт зөвшилцлийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт	Хагас, бүтэн жилийн сүүлийн сарын 25-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	Хагас, бүтэн жилийн дараа сарын 15-ны дотор	ТЗУГ	НХХЯ
4.22	Төсвийн ерөнхийлөн захирагчийн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээний төсөл	12 дугаар сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ТЗУГ			
4.24	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	Яамны нэгжүүд	ХШУДАГ	Дараа оны 04 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭ
4.25	Төсвийн ерөнхийлөн захирагчийн аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний биелэлт	Жилийн сүүлийн сарын 25-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	Дараа оны 04 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭ
4.26	Хагас, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, баланс	07 сарын 15, 03 сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	БТГ ХШУДАГ	БТГ	07 сарын 25, 03 сарын 25-ны дотор	Сангийн
4.27	Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг	02 сарын 01-ны дотор	Төрийн албан хаагчид	ТЗУГ-ын эрх бүхий албан тушаалтан	Дараа оны 03 сарын 01-ний дотор	ТЗУГ	АТГ
4.28	Зам, тээврийн салбарт шинээр байгуулсан гадаад харилцаа, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр, санамж бичиг, протокол	Хагас, бүтэн жилийн дараа сарын 05-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ТЗУГ	Дараа жилийн 01 сарын 15-ны дотор	ТЗУГ	Үндэсний аюулгүй байдлыг зөвлөл

4.29	Зам, тээврийн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөгөө ба төлөвлөгөөний биелэлт	12 сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, агентлаг, харьяа байгууллагууд	ТЗУГ	Дараа оны 01 сарын 15-ны дотор	ТЗУГ	Үндэсний ажлуулга байдлыг зөвлөд, Г
4.30	Яамны үйл ажиллагааны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан				Дараа оны 04 сарын 01-ний дотор	ХШУДАГ	ЗГХЭГ

----- 000 -----